



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/4/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Төлбөрийн акт.....	13
4.2 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/99

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020472

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, starting from the left and extending across the stamp.

Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,228,275.53	65,140,679.20
33	АВЛАГА	20,413.12	1,475,132.99
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	500,000.00
335	Бусад авлага	20,413.12	975,132.99
3351	Байгууллагаас авах авлага	20,413.12	975,132.99
35	БАРАА МАТЕРИАЛ	47,207,862.41	63,665,546.21
351	Түүхий эд материал	28,900,943.40	30,891,340.20
35110	Тусгай зориулалттай материал	27,121,943.40	23,434,840.20
35130	Эм боох материал	1,779,000.00	7,456,500.00
354	Хангамжийн материал	18,306,919.01	32,774,206.01
35410	Бичиг хэргийн материал	1,664,090.00	1,906,390.00
35420	Аж ахуйн материал	7,567,416.00	15,508,416.00
35440	Түлш, шатах тослох материал	720.01	272,200.01
35450	Барилгын засварын материал	3,159,000.00	4,300,000.00
35460	Хүнсний материал	673,300.00	2,761,150.00
35470	Бусад хангамжийн материал	5,242,393.00	8,026,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	734,763,813.19	709,320,044.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	734,763,813.19	709,320,044.41
392	Биет хөрөнгө	639,363,813.19	613,920,044.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	617,538,936.48	617,538,936.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,252,183.12	-43,239,127.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,535,298.00	44,810,298.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,483,188.78	-34,353,959.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,760,126.50	34,434,126.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,460,999.44	-18,551,053.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,010,000.00	16,010,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,101,671.69	-4,546,671.69
39217	Ном	1,817,495.24	1,817,495.24
393	Биет бус хөрөнгө	95,400,000.00	95,400,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	95,400,000.00	95,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	781,992,088.72	774,460,723.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	132,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	132,300.00
413	Өглөг	00.00	132,300.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	132,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	781,992,088.72	774,328,423.61
51	Засгийн газрын хувь оролцоо	781,992,088.72	774,328,423.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	222,077,527.70	222,077,527.70
51101	Өмч: - төрийн	222,077,527.70	222,077,527.70
512	Хуримтлагдсан үр дүн	88,730,104.12	81,066,439.01
51210	Өмнөх үеийн үр дүн	88,730,104.12	88,730,104.12
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-7,663,665.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	471,184,456.90	471,184,456.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	781,992,088.72	774,460,723.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	506,138,475.00	463,525,639.00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	5,248,500.00	9,759,922.00
120	Нийтлэг татварын бүс орлого	00.00	9,759,922.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,675,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,675,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	2,275,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	5,809,922.00
122	Тусламжийн орлого	5,248,500.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	5,248,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,889,975.00	453,765,717.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,701,600.00	373,487,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,701,600.00	373,487,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,649,775.00	15,708,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,649,775.00	15,708,820.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,538,600.00	64,568,997.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,538,600.00	64,568,997.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	510,870,366.91	471,189,304.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	510,870,366.91	471,189,304.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,793,370.13	422,416,189.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,722,407.35	267,886,798.47
210101	Үндсэн цалин	238,775,327.35	267,886,798.47
210102	Нэмэгдэл	21,760,287.00	00.00
210104	Урамшуулал	10,186,793.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,704,340.88	34,563,650.30
210201	Тэтгэврийн даатгал	22,439,111.88	24,384,396.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,699,634.00	2,689,498.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,159,706.00	2,141,519.66
210204	Ажилгүйдлийн даатгал	582,289.00	486,202.98
210205	Эрүүл мэндийн даатгал	5,823,600.00	4,862,032.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,373,330.00	64,076,082.00
210301	Гэрэл, цахилгаан	2,582,695.00	2,330,463.00
210302	Түлш, халаалт	55,344,218.00	53,775,603.00
210303	Цэвэр, бохир ус	7,446,417.00	7,970,016.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,743,936.00	13,000,618.20
210401	Бичиг хэрэг	1,798,270.00	1,245,380.00
210402	Тээвэр, шатахуун	1,084,500.00	729,520.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,378,466.00	1,184,970.00
210404	Ном, хэвлэл	67,500.00	22,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,018,500.00	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,396,700.00	2,574,120.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,824,128.20
2105	Нормативт зардал	29,299,477.83	11,001,175.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,326,530.00	1,197,445.00
210502	Хоол, хүнс	26,732,247.83	9,803,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,416,500.00	1,250,031.00
210604	Урсгал засвар	2,416,500.00	1,250,031.00
2107	Томилго, зочны зардал	24,000.00	96,000.00
210702	Дотоод албан томилолт	24,000.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	824,000.00	768,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,000.00	86,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	331,766.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,685,378.07	29,773,568.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	670,100.00	380,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	23,015,278.07	29,392,768.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,076,996.78	48,773,114.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,764,775.00	15,836,820.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,016,225.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,633,550.00	15,708,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,000.00	128,000.00
2134	Орон нутгийн төсвийн сөрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,165,270.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,165,270.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,146,951.78	32,936,294.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,146,951.78	32,936,294.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,731,891.91	-7,663,665.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,731,891.91	-7,663,665.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	510,889,975.00	455,440,717.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,675,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,675,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,675,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,675,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,889,975.00	453,765,717.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,701,600.00	373,487,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,701,600.00	373,487,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,649,775.00	15,708,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,649,775.00	15,708,820.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,538,600.00	64,568,997.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,538,600.00	64,568,997.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	500,889,974.00	453,766,717.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,889,974.00	453,766,717.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,812,977.22	404,993,602.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,605,566.22	277,503,012.57
210101	Үндсэн цалин	227,241,209.32	214,215,113.08
210102	Нэмэгдэл	31,434,957.15	56,165,915.80
210104	Урамшуулал	15,929,399.75	7,121,983.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,747,700.00	26,269,856.07
210201	Тэтгэврийн даатгал	23,679,400.00	17,356,178.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,767,100.00	2,246,945.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,213,600.00	1,805,461.46
210204	Ажилгүйдлийн даатгал	553,400.00	442,161.01
210205	Эрүүл мэндийн даатгал	5,534,200.00	4,419,110.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,373,330.00	64,076,082.00
210301	Гэрэл, цахилгаан	2,582,695.00	2,330,463.00
210302	Түлш, халаалт	55,344,218.00	53,775,603.00
210303	Цэвэр, бохир ус	7,446,417.00	7,970,016.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,924,166.00	8,044,450.00
210401	Бичиг хэрэг	438,900.00	366,580.00
210402	Тээвэр, шатахуун	1,084,500.00	1,001,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,378,466.00	1,184,970.00
210404	Ном, хэвлэл	67,500.00	580,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,025,700.00	477,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,929,100.00	4,434,100.00
2105	Нормативт зардал	30,965,115.00	14,477,905.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,321,130.00	2,013,145.00
210502	Хоол, хүнс	24,711,885.00	11,891,560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,932,100.00	573,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,911,500.00	8,315,431.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	5,640,000.00
210602	Тавилга	1,675,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,236,500.00	2,675,431.00
2107	Томилолт, зочны зардал	24,000.00	96,000.00
210702	Догоод албан томилолт	24,000.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	816,800.00	711,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	566,800.00	29,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	331,766.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,444,800.00	5,499,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,444,800.00	999,600.00

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,076,996.78	48,773,114.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,764,775.00	15,836,820.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,016,225.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,633,550.00	15,708,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,000.00	128,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,165,270.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,165,270.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,146,951.78	32,936,294.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,146,951.78	32,936,294.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,000,001.00	1,674,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,000,000.00	1,674,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.00	1,674,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00	1,674,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,000,000.00	1,674,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,000,000.00	-1,674,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	01.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	80,563,648.28	773,825,632.88	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	80,563,648.28	773,825,632.88	
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,903,451.41	18,903,451.41	
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	88,730,104.12	781,992,088.72	
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	88,730,104.12	781,992,088.72	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	88,730,104.12	781,992,088.72	
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,663,665.11	-7,663,665.11	
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	81,066,439.01	774,328,423.61	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	443,347,900.00	405,120,602.64	38,227,297.36	91.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,347,900.00	405,120,602.64	38,227,297.36	91.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,219,900.00	404,992,602.64	38,227,297.36	91.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,310,100.00	277,503,012.57	10,807,087.43	96.3
210101	Үндсэн цалин	237,482,500.00	214,215,113.08	23,267,386.92	90.2
210102	Нэмэгдэл	32,731,500.00	56,165,915.80	-23,434,415.80	171.6
210104	Урамшуулал	18,096,100.00	7,121,983.69	10,974,116.31	39.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,785,300.00	26,269,856.07	4,515,443.93	85.3
210201	Тэтгэврийн даатгал	19,648,900.00	17,356,178.08	2,292,721.92	88.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,100.00	2,246,945.06	537,154.94	80.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,227,300.00	1,805,461.46	421,838.54	81.1
210204	Ажилгүйдлийн даатгал	556,800.00	442,161.01	114,638.99	79.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,568,200.00	4,419,110.46	1,149,089.54	79.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,360,000.00	64,076,082.00	5,283,918.00	92.4
210301	Гэрэл, цахилгаан	5,413,400.00	2,330,463.00	3,082,937.00	43.0
210302	Түлш, халаалт	54,596,600.00	53,775,603.00	820,997.00	98.5
210303	Цэвэр, бохир ус	9,350,000.00	7,970,016.00	1,379,984.00	85.2

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2104	Хангамж, бараа материалын зардал	13,425,300.00	8,044,450.00	5,380,850.00	59.9
210401	Бичиг хэрэг	215,200.00	366,580.00	-151,380.00	170.3
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,001,000.00	499,000.00	66.7
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	1,284,700.00	1,184,970.00	99,730.00	92.2
210404	Ном, хэвлэл	364,000.00	580,800.00	-216,800.00	159.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	477,000.00	23,000.00	95.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,561,400.00	4,434,100.00	5,127,300.00	46.4
2105	Нормативт зардал	26,003,100.00	14,477,905.00	11,525,195.00	55.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,109,700.00	2,013,145.00	96,555.00	95.4
210502	Хоол, хүнс	23,319,500.00	11,891,560.00	11,427,940.00	51.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	573,900.00	573,200.00	700.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,336,300.00	8,315,431.00	20,869.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,640,000.00	5,640,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,696,300.00	2,675,431.00	20,869.00	99.2
2107	Томилолт, зочны зардал	119,500.00	96,000.00	23,500.00	80.3
210702	Дотоод албан томилолт	119,500.00	96,000.00	23,500.00	80.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,356,200.00	710,266.00	645,934.00	52.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,200.00	28,500.00	621,700.00	04.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	356,000.00	331,766.00	24,234.00	93.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5524100.00	5499600.00	24,500.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024,100.00	999,600.00	24,500.00	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128000.00	128000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,000.00	128,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,000.00	128,000.00	0.00	100.0
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	443,347,900.00	405,120,602.64	38,227,297.36	91.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,487,900.00	340,551,605.64	32,936,294.36	91.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,487,900.00	340,551,605.64	32,936,294.36	91.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,860,000.00	64,568,997.00	5,291,003.00	92.4
132001	Орон нутгийн төсвөөс	69,860,000.00	64,568,997.00	5,291,003.00	92.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77649775.00	17,383,820.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77649775.00	17,383,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10000000.00	1,675,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10000000.00	1,675,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10000000.00	1,675,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67649775.00	15708820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67649775.00	15,708,820.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51016225.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16633550.00	17,383,820.00
II	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77649775.00	17,383,820.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77649775.00	17,383,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67649775.00	15,708,820.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10000000.00	1,675,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг эрхлэгч Д.Уранчимэг, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-ээс 2021.04.30-ыг хүртэл нягтлан бодогч Э.Билгүүн, 2021.05.01-ээс Я.Тунгалагсансар нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багшийн хөгжлийг дэмжсэнээр хүүхдэд эерэг зан чанар, хандлагыг төлөвшүүлэн, тэдний мэдлэг эзэмших чадварыг хөгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 516,408.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,746.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,422.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар тооцоход 7,067.8 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,531.4 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,228.3	65,140.7	17,912.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	20.4	1,475.1	1,454.7
Бараа материал	47,207.9	63,665.5	16,457.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	734,763.8	709,320.0	(25,443.8)
Үндсэн хөрөнгө	806,561.9	810,510.9	3,949.0
Хуримтлагдсан элэгдэл	(71,798.0)	(101,190.8)	(29,392.8)
Нийт хөрөнгө	781,992.1	774,460.7	(7,531.4)
Өр төлбөр	-	132.3	132.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	781,992.1	774,328.4	(7,663.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	781,992.1	774,460.7	(7,531.4)

Авлагын дансны үлдэгдэл 1,454.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онд ажиллагсадтай холбоотой 20.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэнийг суутган тооцож барагдуулсан ба тайлант онд цалингийн урьдчилгааны 500.0

мянга, хувь хүний орлогын татварын 975.1 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63,665.5 мянган төгрөг болж 16,457.7 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансны үлдэгдэл 5,677.5 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 7,941.0 мянга, барилгын засварын материал дансны үлдэгдэл 1,141.0 мянга, хүнсний материал 2,087.9 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 2,783.7 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 810,510.9 мянган төгрөг болж өмнөх оноос 3,949.0 мянган төгрөгөөр өссөн нь 1,674.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2,275.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн орлого авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 774,460.7 мянган төгрөг болж 7,531.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 7,531.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 658,873.4 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 658,873.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 219,925.5 мянган төгрөгөөр бууруулж 443,947.9 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг 443,347.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 373,487.9 мянга, орон нутгийн төсвөөс 64,569.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 405,120.6 мянган төгрөгийг зарцуулж 32,936.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 405,120.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг 15,322.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,283.9 мянга, хангамж бараа материалын зардлыг 5,380.8 мянга, нормативд зардлыг 11,525.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд нийт 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 471,189.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 39,681.1 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 640,581.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 443,947.9 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 600.0 мянган төгрөг хасаж 373,487.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 69,860.0 мянган төгрөгийн

мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 405,120.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 8.7 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 69,960.0 мянган төгрөгөөр, тодотголоор 69,360.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 61,745.6 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 8,214.4 мянган төгрөг буюу 11.7 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 215.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 366.6 мянган төгрөг зарцуулж төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Эдгээр нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,655.8 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 2,124.4 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 3,651.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,411.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгч, 3,468.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,052.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 552.6 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,022.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 477.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 4,788.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосноос 4,288.4 мянган төгрөгийг суутгаж 500.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг 4 албан хаагчаас суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоогүй урьдчилгааны 500.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Цалингийн зардлаас ажилчдаас суутгасан ҮЭ-ийн татварыг 805.5 мянга, ХХОАТ-ыг 169.6 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлагаар бүртгэж төсөвт зардлыг хэтрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс илүү төлсөн 975.1 мянган төгрөгийг суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Тайлант онд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор тогтоосон хоолны зардлыг нормативыг мөрдөөгүйгээс 546.9 мянган төгрөгөөр хоолны зардлыг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолын 2 дахь “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай” гэснийг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс илүү зарцуулсан 546.9 мянган төгрөгийг холбогдох буруутай ажилтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.2 Албан шаардлага

1. Ажиллагсдын цалинг 2021 оны 04-өөс 12 дугаар саруудад Нийгмийн даатгалын хэлтэст 477.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 477.4 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Тайлант онд тус байгууллага нь нийт батлагдсан төсөвт 8.7 хувийн хэмнэлт гаргасан, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11.7 хувь хэмнэсэн, бичиг хэргийн зардлыг 215.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 366.6 мянган төгрөг зарцуулж төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомж шийдвэрийг цаашид мөрдөж ажиллах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг	6	3052.0	1	552.6	3	2022.0	2	477.4	-	-

_____оОо_____